

**ACTA MONGOLICA**  
CENTRE FOR MONGOL STUDIES  
National University of Mongolia

Vol.8 (306)

2008

057-062

**Эртний солонгос улсын хаадын цол хэргэм  
монгол хэлтэй холбогдох тухай**

**И Сөн Гюү\***

**1. Оршил**

Солонгосын түүхэн дэх хамгийн анхны улс нь Эртний Жусон бөгөөд тус улсын эзэмшил нутгийн хүрээнд Эртний Жусон хэлийг хэрэглэж байсан бололтой. Эртний Жусоныг мөхсөний дараагаар түүний залгамж улс болон тархан нутагласан ард иргэд ч эртний Жусоны хэлийг нэгэн адил хэрэглэж байсан байна. Гэхдээ Эртний Жусон хэл нь ямар онцлогтой хэл байсан талаар баталгаатай тэмдэглэл үлдсэнгүй. Зөвхөн аль нэг овог, үндэстний хэл тийм амар хувьсаж өөрчлөгддөггүй гэсэн онолыг харгалзаж үзэх юм бол одоо бидний хэрэглэж байгаа солонгос хэлтэй холбогдож болох юм.

Эртний солонгос хэлний онцлогийн талаар гогцоо сэжүүр болж буй сурвалж нь “Гурван улсын нохсон судар, Эртний Жусоны булэг”(三國遺事 古朝鮮) юм. Эртний Жусоны булэгийг ажиглан судалбал Солонгос үндэстэн нь нэгдмэл нэг хэлээр бүрэлдэн тогтсон үндэстэн биш байсан бололтой. Ялангуяа, Эртний Жусон улс үүсэн байгуулагдахын өмнө тухайн газар нутагт баавгай болон барсыг шүтэж байсан овог аймаг суурьшин амьдарч байсан ба тэрхүү овгийн сууринд тэнгэр болон нарыг шүтэгч овог отог шинээр ирж суурьшсан гэж таамаглаж байна. Тэгээд тэнгэр, газрыг шүтэгч овог аймаг нь баавгай болон барсыг шүтэгч нутгийн угуул иргэд тэдэнд уусан нэгдсэн юм уу, аль эсвэл тэдэнд эзлэгдсэнээр Эртний Жусоны зонхилогч овог болон түүхийн тавцанд гарч ирсэн бололтой.

Эртний Жусоны булэгт гардаг баримтуудыг хэлний үүдиэс ажиглан харвал хэдэн зүйлийн хэлний булэг Эртний Жусоны нутаг дэвсгэрт оршин байсныг мэдэж болно. Мөн эдгээр хэлний бүлгүүдийн дотроос манай үндэстний нөлөө бүхий бүлгийг бүрэлдүүлсэн зонхилогчийн хэл нь одоогийн солонгос хэлний үндэс болж нөлөө багатай байсан хэлүүд нь устан үгүй болсон юм уу эсвэл зонхилогч хэлэнд аажмаар уусчээ. Гэхдээ тэдгээр бүлгийн хэл нь бүрэн устан алга болсонгүй, зонхилогч хэлэнд ул мөрөө үлдээснээр таамаглаж байна.

\* Дантугийн Их Сургууль, Монгол судлалын тэнхим

Хэлний бүтэц нь тогтолцоог бүрэлдүүлэх бөгөөд үргэлж тухайн тогтолцоон дотроо тогтвортойгоор өөрчлөгдөж байдаг. Хэрвээ тогтвортой байдал үүсэх юм бол өөр тогтвортой тогтолцоо руу шилждэг. Өөр хэлний бүлгийн ормол үг шинээр олон тоогоор нэмэгдсэнээр үндсэн хэлний бүлгийн бүтэц тогтвортойжих байдалтай болвол

- 1) шинээр нэмэгдсэн ормол үгс нь үндсэн хэлний үгийг түлхэн гаргах юм уу,
- 2) үндсэн үгтэй шинээр орж ирсэн үг нь нэгдмэл бүтэцтэй болох эсвэл,
- 3) шинээр нэмэгдсэн ормол үг юм уу үндсэн үгийн аль нэг нь шинэ үүрэгтэй болдог байна.

Уг өгүүлэлд Солонгосын эрт үеийн хэлний онцлогийг хаадын цол нэрд тулгуурлан судлахаар зорилоо. Эрт үеийн хаадын цолд холбогдох материал нь “Гурван улсын нөхсөн судар” (三國遺事)-ын Эртний Жусон (古朝鮮)-ы бүлэг ба Жусон улсын хойч үеийн улсуудын хэлний материалд цөөн тоогоор үлдэж хоцорчээ. Хэдийгээр цөөн тооны боловч эдгээр сурвалжид үндэслэн Солонгосын эрт үеийн хэлний үзэгдлийн талаар тайлбар хийхээс өөр аргагүй юм. Мөн дээр дурдсанчлан эдгээр хэлний сурвалжид ч ижил гаралтай гэхээр хэлний баримт жишээнүүд харагдахгүй байна.

## 2. Солонгосын эрт үеийн хаадын цол

### 1) 檀, 墓 Дан, Данг

“Гурван улсын нөхсөн судар”(三國遺事)-ын Эртний Жусон (古朝鮮)-ы бүлэгт Дангүн Вангом (壇君王儉) гэсэн 2 үг нийлмэл хэлбэрээр тохиолдож байна. Энэ нь Дангүн-ыг Вангом гэж ч дуудаж байсантай холбогдох бололтой. Дангүн болон Вангом нь тус тусдаа салангид үг юм. Дангүн нь “Гурван улсын нөхсөн судар”-аас өөр хувилбарт Вангом-тай нийлмэл байдлаар тохиолдохгүй байгаа бөгөөд тэмдэглэлийн дагуу хөөн үзвээс Вангом-аас Дангүн нь илүү олонтоо тохиолдоно. Магадгүй эрт үед Вангом гэсэн цолоос Дангүн нь илүү өргөн тархацтай хэрэглэгдэж байсан бололтой.

Дангүн (壇君) нь Дан (壇) болон Гүн (君) гэсэн хоёр үгийн нийлц юм. Гүн (君) нь хятад үг бөгөөд Дан (壇) нь Чүэ Нам-Сон (崔南善)-ы дурдсанчлан Чонгүн (天君) гэсэн үг болох юм. Чонгүн нь Гурван улсын тус бүрийн газар нутаг арлыг сахигч хүн бөгөөд тэнгэрт тайлга тахилга үйлдэгч юм. Үүнээс Чонгүн нь тэнгэрт тахилга үйлдэх хүн гэдэг нь тодорхой бөгөөд тэнгэртэй холбоо тогтоодог хүн учир тэнгэрийг илэрхийлсэн ‘Дан’ гэсэн үгийг хэрэглэж байсан гэж дүгнэж байна. Тэнгэр (天) гэдэг үгийн бас өөр нэг хувилбар нь ‘Данг’ бөгөөд энэ ‘Данг’ гэсэн үг нь бөөгийн амьдрах гэр гэсэн утгаар ‘Дангжисиб (당집)’ гэсэн үгэнд үлдэж хоцорчээ. Бас монгол, турк хэлний тэнгэр (tngri) гэсэн үгээр батлах боломжтой. Тухайн үед бидний өвөг дээдэс нь тэнгэрт өргөл тахил өргөх хүнийг Дангүн гэж дуудаж байжээ гэж таамаглаж байна.

### 2) 儉, 今 Гом, Гым

Вангом (王儉) гэдэг үг нь “Гурван улсын нөхсөн судар” (三國遺事)-ын Эртний Жусон (古朝鮮)-ы бүлэг ба “Гурван улсын түүхэн тэмдэглэл” (三國史記)-ийн Дунг-Чон Ван (東川王) - гийн бүлэгт тохиолдоно.

三國遺事 古朝鮮條: 魏書云 乃往二千載 有壇君王儉 立都阿斯達 開國號  
朝鮮...生子 號曰壇君王儉...

三國史記 東川王條: 平壤者 本仙人 王儉之宅也, 或云 王之都王儉

*Дангун* гэдэг үг нь олон зүйлийн сурвалжид түгээмэл тохиолддог ба *Вангом* гэдэг үг нь харьцангуй ховор тохиолдоно. Энэ нь дээр тайлбарласанчлан *Дангун* гэдэг үгийг сүсэг бишрэлийн үүднээс их хэрэглэж байсан бол *Вангом* нь улс төрийн цэргийн жанжныг заасан цолоор хэрэглэж байсан хязгаарлагдмал утгатай байсантай холбоотой бололтой.

*Вангом* нь хятад хэлний ван (王) болон солонгос хэлний уугуул үг gom (儉)-ын нийлмэл бүтэц юм. Өөрөөр хэлбэл, “*Дангун*”-ий үгийн бүтээгдэх адил аардан үеэс бүтсэн үгийн бүрэн бус бүтцийг ойролцоо утгатай хан: үгтэй нэгтгэж бүрэн төгс үгийн бүтцийг үүсгэжээ.

Эрт үеийн цэргийн жанжныг нэрлэсэн цол хэргэм болох ‘Гом’ гэсэн үг байсан гэж үзэх юм бол үүнтэй төстэй Нисагым (尼斯今, 尼師今), Нижилгым (尼叱今), Чижилгым (齒叱今); Мэгым (寐今) гэх мэт үгс бий. Энэ үгийн эцсийн гым нь бүгд Вангомын гом-тай ижил гаралтай гэж үзэж байна. Тиймээс ч энэ үг нь орчин цагийн солонгос хэлний ‘Имгым’ (임금)’ гэсэн үгэнд тэр хэвээрээ хадгалагдан уламжилжээ.

‘Гом’ болон ‘гым’ гэдэг үгийг цэргийн жанжныг нэрлэсэн үг хэмээн тайлбарлай гэвэл угсаатны зүйн үүднээс нь авч үзэх хэрэгтэй болно. Олны мэдэхээр Эртний Жусон (古朝鮮)-ы бүлэгт гардаг гум ( баавгай) нь Зүүн хойд Азийн олон үндэстэн угсаатны сүлд байсаар ирсэн ба ариун дээд зүйл хэмээн шүтэн биширсээр иржээ. Тиймээс энэ гум ( баавгай) гэсэн үг нь цэргийн жанжныг нэрлэсэн үг болж хөгжихэд төвөггүй байжээ. Гум ( баавгай) гэдэг үг нь угтаа задгай үе бүхий ‘гума’ гэсэн үг байжээ. ‘Гума’-гийн эцсийн эгшиг балархайшиж ‘гум’ болсон байна. Мөн <у, о, ы> эгшиг нь авианы өгүүлэх эрхтний гарах байр маш ойр учир 3 төрлийн хэлбэр (гум, гом, гым)-ээр тус тус тэмдэглэж болох юм. Нөгөө талаар энэ үг нь япон хэлэнд бурхан (神) гэсэн утга бүхий ‘гами’ гэсэн үгээр илэрч байна. Солонгос, япон хэлэнд гум гэдэг үг нь цэргийн жанжин, ван, бурханыг заасан үг бөгөөд монгол хэлнээс хайж үзвэл баавгай (baavabaayai) гэсэн үгэнд тохиолдож байна.

### 3) 千, 汗 Кан, Хан

Хан (khan), хаан (khayan) гэдэг цол нь Умардын нүүдэлчин үндэстэн (*Монгол, Түрэг, Хятан, Манж*)-ий хэлний “эзэн хаан” гэсэн утгатай үг юм. Улмаар энэ үг нь солонгос хэлэнд ч ул мөрөө үлдээжээ.

Шилла (新羅) улсын үед эзэн хааныг заасан Госоган (居西干), Госылхан (居瑟邯), Марибан (麻立干), Гагган (角干) гэх мэт үгийн сүүлийн үед ган (干), хан (汗) гэх мэтээр тохиолдож байна. Ган болон хан хэмээх төрөл үг нь Умардын угсаатан үндэстний цэргийн цолыг илэрхийлсэн үг гэдэг нь тодорхой юм. Мөн энэ үг нь Шилла хэлэнд ихээр тохиолдож байгаа нь магадгүй Шилла улсыг байгуулсан үндэстэн болон Умардын үндэстэн аймгуудын хоорондын холбооноос үүдэлтэй гэж үзэхэд хүргэж байна.

### 4) 加, 瑕 Га, Ха

Хятадын 25-тын түүхэн шастирын дундаас Умардын түүх Боть 94 (北史 卷94)-т доорхи тэмдэглэл хадгалагдан үлджээ.

百濟傳, 王姓餘氏, 號於羅瑕, 百姓號爲鞬吉支, 夏言並王也

Эндээс Солонгос нь эрт цагт Бүео овог (Хааны угсааны овог)-ийнхон хааныг Ораха (於羅瑕), харин энгийн ард иргэд Гонгилжи (鞬吉支) хэмээн дууддаг байсан байна. ‘Ораха’ гэсэн хааны цол болох үгийн эцсийн үеийн ‘Ха’ нь Бүео (夫餘) болон Гугүрео (高句麗)-гийн албан тушаалд гарч буй ‘Га (加)’-тай нэг гарал бүхий үг юм. Магадгүй, Бүеогоос салж өмнө зүг нүүж ирсэн Бэгжэ (百濟)-гийн хааны удмынхан өөрсдийн албан тушаалын нэрийг урьдын Бүео, Гугүреод дуудаж байсантайгаа адилаар дуудсаар ирсэнтэй холбон тайлбарлаж болно. Нөгөө талаар, энэ үг нь Гугүрео хэлний Хеон(兄) хэмээх албан тушаалын нэртэй холбогдож болох юм. Хён гэдэг нь монгол хэлээр ‘аq\_a’ гэсэн үг бөгөөд үгийн эцсийн q\_a нь ‘ха’-тай адил хэлбэртэй юм.

### 5) 次次雄, 慈充 **Чачаун, Жачун**

三國遺事 南解王條, 南解居西干 亦云次次雄, 是尊長之稱, 唯此王稱之... 次次雄  
或作慈充, 金大問云, 次次雄 方言謂巫也, 世人以巫事鬼神, 尚祭祀故, 畏敬之, 遂  
稱尊長者 爲慈充

“Гурван улсын нөхсөн судар”-т тохиолдож буй тэмдэглэлийг үндэслэвэл Жачун (慈充) болон Чачаун (次次雄) нь гарал нэг үг бөгөөд энэ нь Госоган (居西干)-тай ижил утга бүхий болохыг мэдэж болохоор байна. Бас Жачун, Чачаун гэдэг нь өргөл тахил барьдаг тахилчийг заасан үг гэдгийг ч мэдэж болно. Гэхдээ орчин цагийн солонгос хэлэнд Жачун, Чачаун-тай холбогдох үг тохиолдохгүй байна. Гэвч Жон Инь-бу (정인보)-гийн “Жусоны түүхийн судалгаа”-нд ‘Сан’ (上) хэмээх үгийг ‘Ча’-гаар уншсан байна гэжээ. Үгийн эхэнд ‘Санха (上下)’-г ‘Чаха (차하)’, ‘Бунсан (捧上)’-г ‘Батча (받자)’-гаар унших юм бол ‘Дээр’(上) гэсэн утга бүхий үгийн солонгос хэлний уугуул үг нь ‘Ча(자)’ хэмээн таамаглаж болно. Мөн Жон Инь-бунийн “Жусоны түүхийн судалгаа”-нд ‘Ыбча’(邑借)-г жишээ татсан ба энэ нь гойд ончтой санал гэж бодож байна. Тиймээс Чачауний ‘Ча’ болон Жачунгийн ‘Ча’ нь ‘Дээр’(上) гэсэн утгыг илэрхийлсэн үг гэдэг нь гарцаагүй юм.

Жачун (慈充) болон Чачаун (次次雄) нь бөөг заасан үг болохыг дээрх Ким Дэ-мүн (金大問)-ий тайлбарт гарч буйгаас мэдэж болно. Бас монгол хэлэнд эрэгтэй бөөг заасан ‘jayirang’ гэсэн үг байх бөгөөд үгийн эхний үе ja нь Жачуний Ча(慈)-тай адил байгаа нь сонирхолтой юм. Нөгөөтэйгүүр, Жачуний үгийн эцсийн Үн (雄), Чун (充)-д холбогдуулж эр, эрэгчнийг заах ‘су’ гэсэн үг байх боловч баталгаатай бус юм. Бас Жачуныг орчин цагийн солонгос хэлний ‘Жүн (lam)’ гэсэн үгээр ч тайлбарласан байдаг. Бөө хүнийг ‘Үн’, ‘Чүн’ гэсэн үгээр дуудаж байсан гэж үзин гэвэл Эртний Жусон (古朝鮮)-ы бүлэгт гардаг ‘Хуанүн (桓雄)’-гийн ‘Үн’ ч бөөг нэрлэсэн үг байсан байх боломжтой.

### 6) 吉支, 奇善, 居世, 居瑟, 吉上 **Гис, Гиж, Гиз**

北史 卷94, 百濟傳 王姓餘氏, 號於羅瑕, 百姓號爲鞬吉支, 夏言並王也

Умардын түүхийн тэмдэглэлд гардаг Гонгилжи (鞬吉支) нь Гон (鞬) + Гилжи (吉支) гэсэн хоёр үгийн нийлмэл бүтэц болох бөгөөд Гилжи (吉支) нь хааныг заасан цол гэж үзсэн байна (李基文 1998:47). Бэгжэгийн нутаг дэвсгэрт байсан Гуанжу (광주)-д хэвлэгдсэн Мянган үсгийн судар (千字文)-т хааныг Гижа (기자) гэсэн нэрлэн тэмдэглэснээс харсан ч Гилжи нь Гиж-г тэмдэглэж байжээ гэдгийг нотолж байгаа зүйл юм. Нөгөөтэйгүүр, үүнтэй

холбогдуулан Шиллагийн анхны хаан болох Хеог Го-сэ (赫居世), Го Со-ган (居西干) зэргийг дурдах хэрэгтэй. Хеог Го-сэ болон Го Со-ган зэрэгт тохиолдож байгаа Го-сэ (居世), Го-со (居西), мөн Го Сыл-хан (居瑟邯) гэсэн үгийн Го-сыл (居瑟) зэрэг нь хойд талын Ган (干)-тай холбогдох үг юм. Дээр бид Ган нь хааныг заасан үг болох тухай авч үзсэн билээ. Бас үндсэн үгтэй шинээр орж ирсэн үг нь нэгдмэл бүтэцтэй болно гэж дээр дурдсан байна. Ингэж үзвэл, Гилжи, Госэ, Гоз, Госыл гэх мэт үг нь юуг илэрхийлж буй нь сонирхолтой юм. Эндээс эдгээр үгийн эртний ханзны дуудлагыг сөхөн үзвэл сонирхолтой дүгнэлт гарч ирж байна. Ялангуяа gis (giz) гэсэн хэлбэр нь бүгд адил хэлбэртэй байна. Gis (gis) гэдэг үг нь Шиллагийн доод тушаалын нэр байсан Гилса (吉士)-д ч тохиолдоно. Нөгөөтэйгүүр, энэ үг нь Хятан хэлэнд ч илэрч болох ба Хятаныг үндэслэгч Гисонкан (奇善汗)-ы Гисон (奇善)-д ч gis гэсэн бүтэц буй бөгөөд 13-р зууны Монголын Чингис хаан (Chinggis khan)-д ч мөн адил gis гэсэн хэлбэр тохиолдож буй.

### 3. Дүгнэлт

Солонгосын эртний хаадын цолд холбогдуулан Эртний Жусон ба түүний залгамж улс болох гурван улсын хаадын цол хэргэмын нэрсийн талаар ажиглалт хийллээ. Орчин цагийн солонгос хэлэнд хэрэглэж байгаа Имгым гэх зэрэг үгэнд тохиолдож байгаачлан хэл гэдэг нь маш урт хугацааны уламжлалтай ба тухайн хэлийг залган авсан угсаатны хэлэнд ч уламжлан үлддэг байна. Дээр тайлбарласан хааны цолд бид эзэн хааныг заасан хоёр зүйлийн хэлбэртэй цол байсныг мэдэж болно. Ялангуяа, эртний хаадын цол нь сүсэг бишрэлийн өнгө аястай үгс байх ба арай хожуу үеийнх нь улс төрийн маягтай байна. Сүсэг бишрэлийн өнгө аяс илүү түлхүү үгс нь Дангун, Жачун зэрэг үг бөгөөд улс төрийн өнгө аяс түлхүү үгс нь Гом (Гым), Га (Ха), Ган (Хан), Гиз (Гиж) зэрэг юм. Эдгээрээс Га (Ха) болон Ган (Хан) нь гарал нэгтэй үг гэж бодож байна. Мөн Гом (Гым) гэсэн үгийг эс тооцвол бусад нь бүгд монгол хэлтэй холбогдох юм.

**Ном зүй**

- 姜信沆(2003), 『韓漢音韻史 研究』, 태학사.
- 고조선사연구회(2007), 고조선의 역사를 찾아서, 학연문화사.
- 김정배편(2006), 한국고대사입문1, 신서원.
- 南豊鉉(1999), 『國語史를 위한 口訣研究』, 太學社.
- 南豊鉉(2000), 『吏讀研究』, 태학사.
- 송기중(2003), 『역사비교언어학과 국어계통론』, 집문당.
- 申采浩(1948), 『朝鮮上古史』, 독립기념관 한국독립운동사연구소 편(2007).
- 윤내현(1995), 고조선 연구, 일지사.
- 李基文(1998), 『新訂版 國語史概說』, 태학사
- 李基白編(1988), 『檀君神話論集』, 새문사.
- 정인보(1946), 『조선사연구』, 박성수 편역/정인보의 조선사연구(2000)
- 지현영(1962), 居西干·次次雄·尼師今에 對하여, 語文學通권 8호.
- 崔南善(1927), 「朝鮮 及 其研究」, 李基白編 檀君神話論集(1988), 새문사.
- Б.Сумьяабаатар (1975), Монгол солонгос түүргэгэтийн угсаа гарал, хэлний холбооны асуудал, БНМАУ, ШУА.